

## ТӨЛБӨРИЙН ДААЛГАВАР № 00001504

Огноо:	2022-11-03	Дансны дугаар	Дүн /тоогоор/ 9,000,000.00
Төлөгч:	Диспетчерийн үндэсний төв ХХК	Дебит	
Төлөгчийн:	Худалдаа Хөгжлийн Банк	406002860	
Хүлээн авагч:	Таяр ХХК	Кредит	
Хүлээн авагчийн:	Голомт Банк	1105047147	
Мөнгөний дүн тоогоор (усгээр)	9,000,000.00		
( Есөн сая төгрөг 00 мөнгө )			
Барааг хүлээн авсан буюу ажил үйлчилгээ гүйцэтгүүлсэн:			
Дагалдах баримтын №	Огноо: 2022-11-03		Дүн (торгуулийн хамт) ****
Төлбөрийн зориулалт (барааны болон ажил үйлчилгээний нэр)	2022/91 тоот гэрээт ажлын төлбөр рд:2699877		Гүйлгээний утга (Төлбөрийн зориулалт)



Гүйцэтгэх захирал: Г. Валенчук  
Тамга

Гүйцэтгэх захирал:  
Тамга

Ерөнхий наяглан бодогч: М. Тогт

Банкинд гүйлгээ хийсэн

... оны ... сарын  
Хадиний ...  
(тэмдэг, гарын усэг)

Төлөх хугацаа

Төлбөрийн ээлж

2022.11.03



БАТЛАВ:

ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ТӨХХК-  
ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/Г.БАЛЖИННЯМ/

БАТЛАВ:

“ТАЯР” ХХК-ИИН ЗАХИРАЛ

/С.СОДБААТАР/



ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2022 оны 10-р сарын 25-ны өдөр

№91/2022

Улаанбаатар хот

Энэхүү ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ /цаашид “Гэрээ” гэх/-ийг Нэг талаас Диспетчерийн үндэсний төв /ДҮТ/ ТӨХХК /цаашид “Захиалагч” гэх/ түүнийг төлөөлж Захиргаа удирдлагын албаны дарга ажилтай Б.Биндэрьяа, Нөгөө талаас 5533597 регистрийн дугаартай Таяр ХХК /цаашид “Гүйцэтгэгч” гэх/ түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал ажилтай С.Содбаатар, /хамтад нь “Талууд” гэх/ нар харилцан тохиролцож Монгол улсын хууль, тогтоомж болон Иргэний хуулийг удирдлага болгон дараах нөхцлөөр харилцан тохиролцож байгуулав

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү гэрээний зорилго нь захиалагч талын хүсэлтийн дагуу Эрчим хүч, ус, цахилгаан дулааны хэмнэлтийг уриалсан сурталчилгааг захиалагчийн шаардлагад нийцүүлэн зохион байгуулж хамтран ажиллахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

### ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 2.1 Гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох ба талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлснээр дуусгавар болно.
- 2.2 Гэрээний хугацаа 2022 оны 10 дугаар сарын 25-аас 2022 оны 12 дүгээр сарын 30-ний өдрийг хүртэл байх бөгөөд дуусгавар болоход талууд гэрээг цаашид үргэлжлүүлэн сунгах хүсэлтэй бол гэрээний 8.1-д заасан журмын дагуу нэмэлт гэрээ байгуулан гэрээнд хавсаргана.

### ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ТӨЛБӨР:

- 3.1 Гэрээний үнэ **9,000,000 /Есөн сая/** төгрөг байна. Үүнд: НӨАТ орсон.
- 3.2 Гэрээний нийт үнэ буюу **9,000,000 /Есөн сая/** төгрөгийг 2022 оны ...-р сарын ...-ний дотор төлөхөөр тохиролцов.
- 3.3 Нийт ажлын задаргаа

Д/д	Ажлын нэр	Нийт үнэ
1	Эрчим хүч, ус, цахилгаан дулааны хэмнэлтийг уриалсан сонирхолтой, олон нийтийн анхаарлыг татах байдлаар зурган контентууд	1,000,000
2	Нийтлэл	4,000,000
3	Мэдээ, мэдээлэл	4,000,000
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>9,000,000</b>
<b>Нийт дун: Есөн сая таван зуун мянган төгрөг</b>		

- 3.4 Захиалагч нь гэрээний 3.2-т заасан хуваарийн дагуу гүйцэтгэгчээс ирүүлсэн нэхэмжлэхийг үндэслэн “Таяр” ХХК-ийн Голомт банк, 1105047147 тоот дансанд төлбөрийг ажлын 5 хоногийн дотор шилжүүлнэ. Төлбөрийн шилжүүлэг нь банк хоорондын гүйлгээ, дансны мэдээллийн зэрүүтэй байдлаас шалтгаалсан алдаатай гүйлгээ гэх мэт бусад шалтгаанаар захиалагч талаас үл хамаарах нэхцлөөс шилжүүлэг удааширсан, хугацаа хэтэрсэн нь гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь гүйцэтгэхгүй байх үндэслэл болохгүй.
- 3.5 Гэрээний үнэ гэрээний 2.1-т заасан хугацаанд өөрчлөгдөхгүй. Хэрэв талууд гэрээний үнэд өөрчлөлт оруулах талаар санал гаргасан тохиолдолд гэрээний 8.1-д заасан журмын дагуу зохицуулна.

### **ДӨРӨВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ:**

#### **Гүйцэтгэгч нь дараах эрхтэй:**

- 4.1.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг захиалагчаас шаардах;
- 4.1.2 Захиалагчийн буруутай үйл ажиллагаа болон гэрээний 8.3.2-т заасан шалтгааны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шаардах;
- 4.1.3 Гүйцэтгэгч нь өөрийн нийтэд хүргэж буй мэдээллийн үнэн зөв байдлыг бүрэн хариуцахыг захиалагчаас шаардах;
- 4.2 Гүйцэтгэгч нь дараах үүрэгтэй:
- 4.2.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг гүйцэтгэх, үүргээ бусад этгээдэд шилжүүлэхгүй байх;
- 4.2.2 Гэрээний хугацаанд захиалагч талын үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээлэл чанартай хийж гүйцэтгэн, захиалагч талд заасан хугацаанд актаар хүлээлгэн өгөх;
- 4.2.3 Гэрээгээр гүйцэтгэсэн захиалагч талд тухай бүрд танилцуулах, батлуулах;
- 4.2.4 Өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас захиалагчид учирсан хохирлыг нөхөн төлөх;
- 4.2.5 Төлбөрийн нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг бүрэн ханган захиалагчид өгөх;

### **ТАВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ:**

- 5.1 Захиалагч нь дараах эрхтэй:
- 5.1.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг гүйцэтгэгчээс шаардах;
- 5.1.2 Гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагаа болон гэрээний 8.3.2-т заасан шалтгааны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шаардах;
- 5.1.3 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх явцад стандарт, техникийн нөхцөлийг хангасан, баталгаажсан тоног төхөөрөмж ашиглахыг шаардах;
- 5.2 Захиалагч нь дараах үүрэгтэй:
- 5.2.1 Гэрээний зүйл болох захиалагч талын үйл ажиллагааны талаарх холбогдох мэдээллийг гүйцэтгэгчид өгөх;
- 5.2.2 Захиалагч талын үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээлэллийн хууль тогтоомжид нийцүүлэн бэлтгэх, үнэн зөв байдлыг хариуцах;
- 5.2.3 Өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас гүйцэтгэгчид учирсан хохирлыг нөхөн төлөх;
- 5.2.4 Гэрээний биелэлтийг хангах зорилгоор өөрийн ажилчдаас гүйцэтгэгчтэй харьцах ажилтныг томилох;
- 5.2.5 Гүйцэтгэгчтэй тохиролцон ажлын гүйцэтгэлийн хуваарийг гаргах;

### **ЗУРГАА. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА:**

- 6.1 Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас нөгөө Талдаа хохирол учруулсан тохиолдолд бодит хохирлыг буруутай тал нөхөн төлнө.
- 6.2 Гүйцэтгэгч нь өөрийн буруугаас үүдэн тохирсон хугацаанд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох зардлыг захиалагчаас шаардах эрхгүй.
- 6.3 Захиалагчийн санаатай буюу болгоомжгүй үйлдлийн улмаас хууль тогтоомж зөрчсөн, бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдсан, ямарваа нэгэн хохирол учруулсан нь

тогтоогдвол гүйцэтгэгч болон гуравдагч этгээдэд учирсан бүх хохиролыг захиалагч барагдуулна.

#### **ДОЛОО. МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛ:**

- 7.1 Энэхүү гэрээ, түүний нөхцөл, гэрээтэй холбогдуулан талуудын шууд болон шууд бусаар олж мэдсэн байгууллага, хувь хүний нууцад хамааралтай аливаа мэдээллийг /цаашид “Мэдээлэл” гэх/ бусдад задруулахгүй байх үүргийг талууд Байгууллагын нууцын тухай хууль болон Хувь хүний нууцын тухай хуулийн дагуу хүлээнэ.

#### **НАЙМ. ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ДУУСГАВАР БОЛГОХ, ЦУЦЛАХ:**

- 8.1 Энэхүү гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд эх хувьд засварласан буюу бусад аргаар оруулсан аливаа нэмэлт өөрчлөлтийг хүчингүйд тооцно. Энэхүү нэмэлт, өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 8.2 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлсэн, гэрээний 2.1-т заасан хугацаа дуусгавар болсноор гэрээ дуусгавар болно. Хэрэв гэрээний 8.1-д заасан журмын дагуу гэрээний хугацаанд өөрчлөлт орсон бол өөрчлөлт орсон хугацааг дагаж мөрдөнө.
- 8.3 Гэрээг дараах тохиолдолд цуцлаж болно;
- 8.3.1 Талууд харилцан тохиролцсон;
  - 8.3.2 Талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, биелүүлэхээс татгалзсан тохиолдолд нэг талын санаачлагаар;

#### **ЕС. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ:**

- 9.1 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлс /дайн, байлдаан, иргэний бослого хөдөлгөөн, нийтийг хамарсан хориг, цар тахал, бүслэлт, байгалийн гамшиг, цахилгаан эрчим хүчиний саатал зэрэг аль нэг талын буруугаас үл хамаарах хүчин зүйлс/-ээс шалтгаалсан онцгой нөхцөл байдлын улмаас аль нэг тал нь энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд тухайн нөхцөл байдал дуусах хүртэлх хугацаанд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээс чөлөөлөгднө.
- 9.2 Давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалсан онцгой нөхцөл байдал 3 /гурван/ сар хүртэл хугацаагаар үргэлжилвэл аль ч тал энэхүү гэрээг дангаар цуцлах эрхтэй.


#### **АРАВ. БУСАД ЗҮЙЛ:**

- 10.1 Гэрээг адил хүчинтэй 3 хувь үйлдэж, захилагч 2 хувь гүйцэтгэгч 1 хувийг хадгална.
- 10.2 Энэхүү гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг гэрээ байгуулах үед Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомж болон Иргэний хуулийн тогтоомжийн дагуу зохицуулна.
- 10.3 Талуудын хооронд гэрээнээс үүдэн гарсан аливаа маргааныг эвийн журмаар, харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

#### **ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

##### **ЗАХИЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

ЗУА-ИЙН ДАРГА

  
/Б.БИНДЭРЬЯА/

СЭЗА-НИЙ ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ  
НЯГТЛАН БОДОГЧ

  
/Т.БЯМБАЖАВ/

ХУУЛЬЧ

  
/Б.АНХЗАЯА/

##### **ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР

  
/Т.НОМИН/

ЗУА-НЫ ХУДАЛДАН АВАЛТ ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН /Э.ӨЛЗИЙМАНДАХ/  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН /С.НАМЧИНДОРЖ/

**ХАЯГ:**

Монгол Улс, Улаанбаатар хот 17060 Хан-  
уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн Өргөн  
чөлөө Засгийн газрын XIV байр 4,5 давхар  
Утас: 7004 1371, 91177701

**ХАЯГ:**

Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, 3 тоот  
Утас: 99771715  
Имэйл: nomin.tmrblr@gmail.com

Борлуулагч  
ТТД: 5533597  
Нэр: ТАЯР  
Хаяг: Монгол, Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, 36, 3

Банкны нэр: Голомт банк  
Банкны дансны дугаар: 1105047147

Худалдан авагч  
ТТД: 2699877  
Нэр: Диспетчерийн үндэсний төв  
Хаяг: Монгол, Улаанбаатар, Хан-Уул, 3-р хороо, Хан-уул Чингисийн өргөн чөлөө 3-р хороо, 413 тоот

ДДТД: 000005533597000221201000001769913

Огноо: 2022-11-30 23:59:59

Nº	Бараа	т/ш	ҮНЭ	Дүн
1	Гэрээт ажлын төлбөр	1	9,000,000.00	9,000,000.00
	Нийт үнэ:	9,000,000.00		
	НӨАТ:	0.00		
	Бүгд үнэ:	9,000,000.00		

